



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/612

Булган сум

**Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах
гэрээ байгуулах, эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 291 дүгээр зүйлийн 291.7 дах заалт, Засгийн газрын 2022 оны “Тусгай зориулалтаар 2023 онд агнах, барих агнуурын амьтны тоо толгойг тогтоох тухай” 444 дүгээр тогтоол, 2023 оны “Амьтны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоол, “Босго үнийн хэмжээ тогтоох тухай” 261 дүгээр тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Хуваарь батлах тухай” А/215 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, зөвшөөрөл олгох дуудлага худалдааны нэр бүхий ялагчийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, зөвшөөрөл олгох, дуудлага худалдааны нэр бүхий ялагчтай “Агнуурын амьтныг агнах, барих” гэрээ байгуулж, тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах зөвшөөрлийн үнэ, төлбөр хураамжийг хуульд заасан хугацаанд, холбогдох дансанд төвлөрүүлж, дуудлага худалдааны ялагч нарт тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

В.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны
08 дугаар сарын 28-ны өдрийн А/612 дугаар
захирамжийн хавсралт

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН БОРХУУТ, МОГОД СУМЫН ХУЛЬЖ-НОМГОН АГНУУРЫН
БҮС НУТГААС ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР АГНУУРЫН АМЬТНЫГ АГНАХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ДУУДЛАГА ХУДАЛДААНД ЯЛАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Ялагч байгууллагын нэр	Амьтны зүйлийн нэр	Дуудлага худалдаа	Тоо толгой (ширхэг)	Төлвөл зохих Мөнгөн дүн (төгрөгөөр)
1	2	3	4	5	6
1	Ханхархайрхан ХХК	Халиун буга	1-р багц	1	3,900,000
2	Ханхархайрхан ХХК	Халиун буга	2-р багц	1	4,520,000
3	Ханхархайрхан ХХК	Халиун буга	3-р багц	1	5,150,000
4	Монгол сафари ХХК	Халиун буга	4-р багц	1	3,060,000